Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
Үнэт цаасны бүртгэлийн журмын 4 дүгээр хавсралт

| **Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/** | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл илгээж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| Тайлагнах хугацаа | 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | "Инвескор ББСБ" ХК<br>9010002004<br>MN00INV05533<br>77090077 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | Монголын Хөрөнгийн Бирж |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Санхүүгийн үйлчилгээ |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | “"БДО Аудит" ХХК |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 75,744,281 ширхэг энгийн хувьцаа |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | **Бэлтгэсэн:**<br>СУХЗГ, Санхүүгийн менежер Г. Номундарь<br>**Хянасан:**<br>Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал А. Түвшинжаргал<br>Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал С.Тулга |

| | |
|---|---|
| 1. | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ |

**Санхүүгийн байдлын үзүүлэлт**

| 000' MNT | (2023.12.31) | (2022.12.31) |
|---|---|---|
| ***ХӨРӨНГӨ*** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 81,902,828 | 50,043,133 |
| Хөрөнгө оруулалт | 7,587,265 | 6,922,715 |
| Харилцагчдад олгосон зээл-цэвэр | 484,418,215 | 282,331,254 |
| Нийт зээл | 492,802,116 | 282,556,026 |
| Эрсдэлийн сан | (19,970,333) | (8,179,393) |
| Хүүний авлага | 11,586,432 | 7,954,531 |
| Авлага | 4,455,799 | 2,030,566 |
| Өмчлөх бусад ул хөдлөх хөрөнгө | 1,025,379 | 561,450 |
| Бусад актив | 2,306,322 | 8,934,238 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 18,929,977 | 7,687,545 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **600,625,785** | **358,510,901** |
| ***ӨР ТӨЛБӨР*** | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 141,098,586 | 85,440,869 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 202,778,982 | 69,458,371 |
| Бонд | 67,443,386 | 44,170,514 |
| Бусад өглөг | 33,595,298 | 36,187,806 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **444,916,252** | **235,257,560** |
| ***ӨӨРИЙН ХӨРӨНГӨ*** | | |
| Хувьцаат капитал | 17,193,952 | 17,193,952 |
| Нэмж төлөгдсөн капитал | 29,820,733 | 29,820,733 |
| Хоёрдогч өглөг болон эздийн өмчийн бусад хэсэг | 5,000,000 | 5,000,000 |
| Өөрийн хөрөнгийн бусад хэсгүүд | (1,663,183) | 622,901 |
| Хуримтлагдсан ашиг /(алдагдал)) | 105,358,031 | 70,615,756 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **155,709,533** | **123,253,342** |
| **Нийт пассив ба өөрийн хөрөнгө** | **600,625,785** | **358,510,901** |

*аудитлагдсан

**Орлогын тайлан**

| 000' MNT | (2023.12.31) | (2022.12.31) |
|---|---|---|
| **Хүү болон түүнтэй адилтгах орлого** | **126,148,950** | **81,051,602** |
| **Хүү болон түүнтэй адилтгах зардал** | **46,738,781** | **25,604,130** |
| Бусад хүүгийн зардал | 25,071,325 | 14,286,167 |
| Итгэлцлийн үйл ажилллагааны зардал | 21,667,456 | 11,317,963 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 7,431,401 | 5,100,701 |
| **Хүүгийн цэвэр орлого** | **79,410,169** | **55,447,472** |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 14,915,416 | 13,244,471 |
| Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал) | (159,573) | (35,824) |
| Бусад хүүгийн бус зардал | 182,600 | - |

| | | |
|---|---|---|
| **Нийт хүүгийн бус цэвэр орлого** | **14,938,443** | **13,208,647** |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | **86,917,211** | **68,656,119** |
| Ажиллагсадтай холбогдолтой зардал | 13,864,945 | 8,858,395 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 13,498,980 | 11,434,683 |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | **27,363,925** | **20,293,078** |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 865,506 | (299,234) |
| **Татварын өмнөх ашиг** | **60,418,792** | **42,963,106** |
| Орлогын албан татвар | 15,150,719 | 9,337,543 |
| ***Тайлант үеийн цэвэр ашиг*** | **45,268,073** | **33,625,564** |

*аудитлагдсан

| | | |
|---|---|---|
| 1.1. | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | |
| | *To be updated | |
| 1.2. | Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ | |
| | *To be updated | |
| 2. | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | |
| 2.1. | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | ✓ Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (5.5% Хангасан)<br>✓ ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа (3.6% Хангасан)<br>✓ ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (2.4% Хангасан)<br>✓ Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (11.7% Хангасан)<br>✓ Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (8.9% Хангасан)<br>✓ Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (-15.3% Хангасан)<br>✓ Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (96% Хангасан)<br>✓ Өрийн бичгийн зохистой харьцаа (47% Хангасан)<br>✓ Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа (1.3% Хангасан)<br>***Тусдаа тайлангаар** |

<table>
<tr>
<td>2.2.</td>
<td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</td>
<td>✓ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (25.3% Хангасан)<br>✓ Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (25% Хангасан)<br>✓ Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (25.9 Хангасан)<br>✓ Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (24% Хангасан)<br><br>*Тусдаа тайлангаар</td>
</tr>
<tr>
<td>2.3.</td>
<td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</td>
<td>Зээлийн багц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн багц 79%-р өсөж 504 тэрбум төгрөг, харилцагчийн тоо 27 хувиар өсч 231 мянгад тус тус хүрсэн байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 529 ББСБ-ын 7.1 их наядын зээлийн багцын 13.9 хувийг "Инвескор ББСБ" ХК бүрдүүлж байна.<br>Зээлийн багцыг бүтээгдэхүүнээр ангилахад дараах бүрэлдэхүүнтэй байна.<br>✓ Бизнесийн зээл-59%<br>✓ Автомашины зээл-12%<br>✓ Хэрэглээний зээл-6%<br>✓ Дижитал зээл-23%<br>Компани цаашид хэрэглээний зээлийг бүрэн автоматжуулах, бизнесийн зээл рүү илүү төвлөрч жижиг дунд бизнес эрхлэгчдээ дэмжин ажиллах бодлого баримталж байна.</td>
</tr>
<tr>
<td>2.4.</td>
<td>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</td>
<td>Балансын гадуур бүртгэгдсэн хүүгийн орлого болон зээлийн барьцаа хөрөнгийн талаар мэдээлэл.<br><table><tr><td>Зээлийн барьцаа хөрөнгө</td><td>461,186,071,490 төгрөг</td></tr><tr><td>Зээл болон бусад хөрөнгийн тооцоо</td><td>6,054,322,096 төгрөг</td></tr></table></td>
</tr>
<tr>
<td>2.5.</td>
<td>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</td>
<td>Тайлант хугацаанд 170.5 тэрбум төгрөгийн зээл авч, 49.6 тэрбум төгрөгийн төлөлт хийсэн байна.</td>
</tr>
<tr>
<td>3.</td>
<td colspan="2">Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</td>
</tr>
<tr>
<td></td>
<td colspan="2">Тайлант хугацаанд 9 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан байна.<br>Их хэмжээний хэлцэл хийгдээгүй.</td>
</tr>
</table>

| | |
|---|---|
| 4. | Цалин урамшууллын мэдээлэл |
| | 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшуулалд 138 сая төгрөг зарцуулсан байна.<br>Төлөөлөн удирдах зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор батлуулдаг болно. |
| 5. | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл |
| | Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн<br>Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд үүний 3 нь хараат бус байна.<br>ТУЗ-ийн дэргэд түүний гишүүдээс бүрдсэн Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын, Эрсдэлийн удирдлагын хороод байнгын үйл ажиллагаа явуулдаг. Хороод тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэй.<br>2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц дунджаар 89% байна. |






**Дотоод аудитын тогтолцоо**

Байгууллага нь хамгаалалтын гурван бүс бүхий эрсдлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд Дотоод аудитын газар нь хамгаалалтын гуравдугаар бүсийн чиг үүрэг болох хараат бус баталгаажуулалтаар хангаж ажилладаг.

Компанийн бүтцийн хувьд дотоод аудитын газар нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлага доор үйл ажиллагаагаа явуулдаг.

Дотоод аудит нь оновчтой, эрсдэлд суурилсан хандлагаар байгууллагын Эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо, засаглал болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх бөгөөд Компанийн үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт хийх, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлж зөвлөмж гаргах, компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн үнэ цэнэ нэмэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаа явуулж буй зах зээл дээрх томоохон хэмжээний өөрчлөлт, сөрөг өөрчлөлт болон үнийн хэлбэлзлээс үүдэн эдийн засгийн үнэ цэнэ, орлогын хэмжээнд учирч болох алдагдлаас урьдчилан сэргийлэхийн тулд доорх алхмуудыг авч хэрэгжүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

- ✓ Гадаад улс орнуудад шинэ зах зээл нээж, санхүүгийн экспорт хийх;
- ✓ Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл болон харилцагч нарын сегментийг төрөлжүүлэх;
- ✓ Эх үүсвэр татах арга хэрэгслүүдээ төрөлжүүлэх;
- ✓ Эдийн засаг болон улс төрийн нөхцөл байдлыг тогтмол ажиглаж, бодитой үнэлэлт дүгнэлт өгөх;
- ✓ Зах зээлийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохицуулагч байгууллагууд болон мэргэжлийн холбоонуудтай хамтран ажиллах.

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/

| Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
|---|---|---|
| "Эс Ай Би Жэй Капитал" ХХК | 60,968,730 | 80.49% |
| Олон нийт | 14,775,551 | 19.51% |
| Нийт | 75,744,281 | 100.00% |

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1758 хувьцаа эзэмшигч байна.

Үнэт цаас гаргагчийн охин компаниуд

- ✓ "Инвескор Си Эй МФК" ХК-73.6%
- ✓ "Покет КГ" ХХК-100%

| | |
|---|---|
| | ✓ "Инвескор Хэтэвч ББСБ" XXK-100%<br>✓ "Инвескор КЗ" XXK-100%<br>✓ "Инвескор Юү И" XXK – 100% |
| 8. | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл |
| | Инвескор ББСБ ХК нь 4,016,363 ширхэг нэмэлт хувьцаагаа тус бүр нь 4,155 төгрөгийн үнээр олон нийтэд санал болгож 16.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Уг хөрөнгийн 30 хувийг гадаад буюу Төв азийн зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд, үлдсэн 70 хувийг Монгол улс дахь бизнесийн үндсэн үйл ажиллагаа буюу харилцагчдад олгох зээлийн багцыг санхүүжүүлэхээр төлөвлөж байсан. Төлөвлөгөө ёсоор татан төвлөрүүлсэн хөрөнгийн 70 хувийг Монгол улс дахь зээл олголтод зарцуулсан бөгөөд 30 хувийг Киргиз улс дахь охин компанийн зээл олголтыг санхүүжүүлэхэд болон Төв Ази руу чиглэсэн бусад хөрөнгө оруулалтуудад зарцуулсан. |
| 9. | Ногдол ашгийн мэдээлэл |
| | "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн №09 тоот тогтоолоор 2022 оны цэвэр ашгаас нийт 4,014,446,932 төгрөг буюу нэгж хувьцаанд 53 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн.<br><br>Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосон бөгөөд 2024 оны 4 дугаар сарын 30-ны өдөр ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд байршуулсан. |
| 10. | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл |
| | **Жижиг дунд бизнес эрхлэгчид болон зорилтод бүлгийг дэмжих хөтөлбөр**<br><br>"Инвескор ББСБ" ХК нь Олон улсын Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой Хөгжлийн Төлөөх Үндэсний Чуулган"-тай хамтран Жижиг Дунд Бизнес эрхлэгчид болон зорилтот бүлгийн буюу өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэйчүүдийн бизнесийг дэмжиж, хөнгөлөлттэй зээл олгох зэргээр хувь нэмрээ оруулан хамтран ажиллалаа. |

Ковид-19 цар тахлын дараа Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг "Инвескор ББСБ" ХК нь "Рио Тинто Монгол" ХХК-тай хамтран хэрэгжүүлж амжилттай дууслаа. Зээлийн багцын 77 хувь нь импортыг орлох бүтээгдэхүүнд, 57% нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд, 12% нь хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч, өрх толгойлсон эцэг/эхийн бизнес, байгальд ээлтэй бизнес эрхлэгчдэд тус тус зарцуулагдсан байна.

**Тэрбум мод аян**



Инвескор Санхүүгийн байгууллага, Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо гишүүн байгууллагуудын хамт "Мянж үржүүлэх, нутагшуулах төв"-д байрлах "Цэцэрлэгт хүрээлэн"-д мод тарих арга хэмжээнд оролцож 4 төрлийн 720 мод тарихад гар бие оролцлоо.

**Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооны хамтын ажиллагаа**




"Инвескор ББСБ" ХК нь ТоС Холбооны дэргэдэх ББСБ-ын ТоС мэргэжлийн зөвлөлийн ээлжит уулзалтыг зохион байгуулж, өөрийн хэрэгжүүлж буй Байгаль орчин, нийгмийн бодлогын хэрэгжилт болон Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаар гишүүддээ танилцуулж, туршлага хуваалцлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Зээлийн бодлогод "Санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт"-ыг багтаасан байдаг бөгөөд тус жагсаалтын дагуу Инвескор ББСБ ХК нь байгаль орчин, нийгэмд өндөр хор хөнөөлтэй үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй.

<table>
<tr><td></td><td>Түүнчлэн, харилцагчийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлон үнэлж, бууруулах зорилгоор “Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирhдлагын журам” батлуулан зээлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.</td></tr>
<tr><td colspan="2">Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</td></tr>
<tr><td colspan="2">Овог, нэр: С.Тулга<br>Албан тушаал: Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал<br>Гарын үсэг: ……<br><br>Овог, нэр: А. Түвшинжаргал<br>Албан тушаал: СУХЗГ-ын захирал<br>Гарын үсэг: …</td></tr>
<tr><td colspan="2">Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</td></tr>
<tr><td colspan="2">Овог, нэр: Г. Номундарь Албан тушаал: Санхүүгийн менежер<br>Гарын үсэг: ……………………………………………..</td></tr>
</table>